



GRANVIA



**TOYOTA
HIACE**



Ойрын болон холын диодон их гэрэл



Томсгосон орц, гарц болон хажуугийн хаалга

ТӨГС АЖИЛ

Тээврийн салбарын түүхэнд хамгийн амжилттай яваа загварын нэг болох Toyota Hiace-ийн шинэ үе болон гарч ирсэн загварыг танилцуулъя.

Бат бөх чанартай, шувтан кузовын шинэлэг хэв маяг нь шаардлага өндөртэй зорчигчдын хэрэгцээг хангахад чиглэгдсэн орчин үеийн дэгжин автомашины төрхийг бүрдүүлжээ. Гаднах фасадны давтагдашгүй эд ангиуд нь минивэны дараагийн үеийн эрхэмсэг төрхийг тод илтгэнэ. Та ч бас шинэ Toyota Hiace-ийн гялгар тоноглол, 16 инчийн төмөр обуд болон диодон их гэрлийн содон загварыг таатай хүлээж авах нь гарцаагүй.

НАЙДВАРТАЙ БАЙДАЛ БОЛОН ТОХИЛОГ ОРЧИН

Шинэ платформ, улам бат бөх болгож сайжруулсан кузовтой Toyota Hiace-ийн 6 дахь үеийн загвар нь таны аюулгүй байдал, тав тухын түвшнийг шинэ шатанд гаргах найдвартай анд байх болно. Энэхүү загвар богино капот бүхий бүтэцтэй тул жолооч, зорчигчдын аль алинд саруулхан, аюулгүй орчинг мэдрүүлнэ.



АЖЛЫН ОРЧИН

Шинэ Toyota Hiace илүү том овортой болсон. Ачааны загвар нь 9.3м³ хүртэл тээшний багтаамжтай ба суудлын загвар нь 16 хүртэлх суудлын сонголттой байна.





ХЯНАЛТ БА БОЛОМЖ

Toyota Hiace-т жолооч болон урд зорчигчид зориулж 1 бүст агааржуулагчийн удирдлага суурилуулсан байгаа бол салоны зорчих хэсэгт кондишн, цахилгаан паар нэмж тавьсан байна. Иймд энэ цагаас эхлэн өвлийн хүйтэнд ч салон нь үргэлж дулаахан явах боллоо. Мөн дуу чимээ тусгаарлах системийг сайжруулсан учраас жолооч, зорчигчид аядуу орчинд таатай зорчих боломжтой боллоо.



Шинэ Toyota Hiace-ийн олон үйлдэлтэй жолооны хүрдний сайтар тооцоолж боловсруулсан бүтэц, загвар нь жолоочид залах үедээ анхаарлаа сарниулалгүй бүх системийг удирдаж явах боломжийг олгоно. Рулийг нааш цааш, дээш доош тохируулж болох учраас жолооны ард тухтай явах нөхцөл бүрдсэн.





САРУУЛХАН ЗАЙ, ТОХИЛОГ БАЙДАЛ

Шинэ Toyota Hiace том овор хэмжээ, кузовын бүтцийн өөрчлөлтийн улмаас өмнөх үеэсээ хамаагүй саруулхан, тохилог болсон юм. Ингэснээр суудал хоорондын зай өргөсөж, орж гарахад эвтэйхэн болсны сацуу хөл хэсгийн зай нэмэгдсэн. Толгойн түшлэгтэй сайжруулсан суудлуудын налууг тохируулж болох тул жолоочоос гадна 16 зорчигч алс холын замд тав тухтай аялах нөхцөл бүрджээ. Түүнчлэн өнөөгийн Toyota Hiace-т суудлуудаа эвхэн ачаа зөөвөрлөх орон зайг нэмэх боломжтой.



ДОТОР ЗАСАЛ





ИТГЭЛ БА ХҮЧ

Шинэ Toyota Hiace өөрийн нэр хүнд, хурц төрхөө батлан харуулж чаддаг. Учир нь энэхүү автомашинд хүч авалт сайтай, түлшинд хэмнэлттэй 2.8 л турбо дизель хөдөлгүүрийг 6 шатлалт механик болон автомат хурдны хайрцагтай хослуулж суурилуулсан байна. 1GD-FTV Global Diesel гэх энэхүү хөдөлгүүрээр Toyota Land Cruiser Prado зэрэг манлай автомашинуудыг ч бас тоноглодог юм.





TOYOTA GRANVIA



АМЬДРАЛД ОЙР, ТОП ЗЭРЭГЛЭЛИЙН ЗАГВАР

Granvia-д суусан хүн бүр эвтэйхэн гүнзгий суудалтай тансаг орчин болон хөл хэсэгтээ уужуу суудал хооронд сүлжиж явах зай ихтэй саруулхан салоноос сэтгэлийн ханамж авах нь гарцаагүй. Зорчигчдыг аян замд тавлаг зорчуулахын тулд 6 суудалтай Granvia загварт бүх суудлуудыг халаагуураар тоноглосон бөгөөд суудлуудыг цахилгаан тохируулгатай болгосон байна. Зөөлөн даралттай мэдрэгч болон ухаалаг технологиуд салоны тансаг орчинг бүрдүүлэхэд одоо ч тусалсаар байгаа билээ.

ГАДНАХ ТӨРХ





TOYOTA GRANVIA


Зорчигчдод бууж суухад эвтэйхэн байх үүднээс хаалганы өндөр болон өргөний хэмжээг нэмсэн. Мөн хаалгануудыг цахилгаан хүчлээр, автомат татуургаар тоногловсон учир чимээгүй нээгдэж хаагддаг болжээ. Тав тухыг нэмэхийн тулд хаалгаар орох хэсэгт бариул тогтоож, шалны доод хэсгийг гэрэлтүүлэгтэй эвтэйхэн гишгүүрээр тоногложээ.



Салоны савхин хийцэд натурал болон синтетик савхины хослолыг ашигладаг.

ДОТОР ЗАСАЛ







9 SRS ослын дэр

ТООЦООЛОЛ БА АНХААРАЛ

Урд хэсэгт суурилуулсан ослын 2 ширхэг дэр, 3 цэгт бэхлэгддэг аюулгүйн бүс зэрэг нь жолооч болон бусад зорчигчдод аян замдаа амар тайван зорчих нөхцөлөөр хангадаг.

Салоны тохилог байдлыг дээшлүүлэх сүүлийн үеийн шийдэл, нарийн тооцоолж бүтээсэн загвар нь ачаа тээшний зайг улам томруулж өгч чадав.





1E7 Мөнгөлөг



4R4 Металлик Шаргал



058 Цагаан



070 Сувдан Цагаан



1F7 Сувдан саарал



1G3 Металлик саарал




202 Хар

11 Хар, Саарал



021 Хар



КУЗОВЫН ӨНГӨ | САЛОНЫ ӨНГӨ



TOYOTA СЕРВИС

Авахад амар, хэрэглэхэд хялбар.

- Дугуй солих үйлчилгээ.
- Дугуй хадгалах үйлчилгээ
- Тос солих үйлчилгээ
- Оношилгоо
- Тэнхлэг тохиргоо
- Оригинал сэлбэг





ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ

Үйлчилгээний төрөл	1,000км тутам	5,000км тутам	10,000км тутам
 Хөдөлгүүрийн тос болон тосны шүүр солих	.	.	.
 Бүх амин чухал холбоос болон эд анги шалгах	.	.	.
 Ажлын шингэнүүдийн түвшин шалгах	.	.	.
 Дугуйн хий болон дугуйн даралт шалгах	.	.	.
 Салоны шүүр буюу агаар шүүгч солих		.	



САНХҮҮЖИЛТ, ЗЭЭЛ

Эрхэм та шинэ автомашин авахаар төлөвлөж байгаа бол бид хамгийн таатай нөхцөлтэй шуурхай, хялбар Лизингийн үйлчилгээ санал болгож байна.

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Тухайн бизнесийн үйл ажиллагаагаа 12 сар эрхэлж буй.
Идэвхитэй хугацаа хэтэрсэн болон муу зээлийн түүхгүй байх.
Ашиг орлогоороо түрээсийн төлбөрийг бүрэн төлөх боломжтой байх.

ИРГЭН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

Иргэний үнэмлэхний (ИҮ) хуулбар;
Орлого тодорхойлох баримтууд:
Дансны хуулга
Ажлын гэрээ
Өөрийн машин механизмын гэрчилгээ.

БАЙГУУЛЛАГЫН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

ААН - ийн гэрчилгээ, дүрэм;
Гүйцэтгэх захирлын ИҮ-ний хуулбар;
Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан;
Эрх бүхий этгээдийн зөвшөөрөл;
Бизнесийн орлого тодорхойлох баримтууд.



Овор хэмжээ	Hiace Cargo	HiaceMT	HiaceAT	Granvia
Урт	5,915 мм	5,915мм	5,915мм	5,265 мм
Өргөн	1,950 мм	1,950 мм	1,950 мм	1,950 мм
Өндөр	2,280 мм	2,280мм	2,280мм	1,990 мм
Эргүүлэх хүчний хамгийн дээд хязгаар, Нм / эрг/мин	420/2600	420/2600	351/4600	351/4600
Хөтлөгч	RWD	RWD	RWD	RWD

Үзүүлэлт				
Хөдөлгүүр	1GD-FTV	1GD-FTV	7GR-FKS	7GR-FKS
Моторын багтаамж, СС	2755cc	2755cc	3456cc	3456cc
Шатахууны төрөл	Diesel	Diesel	Petrol	Petrol
Шатахууны савны эзлэхүүн, л	70	70	70	70
Хурдны хайрцаг	6 M/T	6 M/T	6 A/T	6 A/T
Суудлын тоо	3	16	16	6
Дугуй	215/70R16	235/65R16	235/35R16	235/60R17
Хаалганы тоо	3	4	4	5

Шатахуун зарцуулгыг тааламжтай орчинд тооцож гаргасан тул шатахууны зарцуулгад нөлөөлдөг жолоодох арга барил, ашигласан түлш шатахуун, хөдөлгөөний горим, маршрут, автомашины ачаагүй үеийн жин, замын нөхцөл болон цаг агаар зэрэг олон хүчин зүйлийг орхигдуулсан болно. Түлш шатахууны бодит зарцуулга нь танилцуулгад дурдсан хэмжээнээс зөрж болох бөгөөд зөвхөн туршилтын аргаар тодорхойлогддог юм. Танилцуулгад дурдсан мэдээлэл зөвхөн хэвлэгдсэн цаг хугацаандаа хүчинтэй байна. Кузовын өнгөний сонголт каталогт танилцуулсан өнгөнөөс бага зэрэг ялгаатай байж болзошгүйг анхаарна уу. Каталогт дурдсан техник үзүүлэлт болон тоноглолын сонголт зэрэг нь тухайн бүс нутгийн онцлог, шаардлагаас хамааралтай байдаг учраас зарим загвар үндсэн загвараасаа ялгаатай байж болно.